

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр

№ 23/27

Улаанбаатар хот

Хаалттай хүрээнд өрийн хэрэгсэл гаргах тухай


Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.4, 41.5 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дах заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дах хэсэг, 80.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.4 дэх заалт Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 23/11 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөө”, Компанийн ТУЗ-ийн 2023 оны 11 дугаар сарын 09-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор нийт 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл (цаашид “Өрийн хэрэгсэл”)-ийг гаргаж санхүүжилт татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Компанийн гаргаж буй Өрийн хэрэгслийг “Монгол Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо ӨЗБ” ГҮТББ-ын зохицуулалтад байх Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлж хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон арилжаалсугай.
3. Өрийн хэрэгслийн ерөнхий нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтад зааснаар баталсугай.
4. Өрийн хэрэгслийн ерөнхий нөхцөлийн хүрээнд, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээ, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан Өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд хэсэгчлэн (транч) гаргах хувь хэмжээ, хэсэгчлэн гаргах хугацааг тухай бүр нарийвчлан тогтоох эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
5. Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлд Өрийн хэрэгслийг бүртгүүлэх, анхдагч зах зээлд арилжаалахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагаар “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК-ийг сонгосугай.
6. “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК-тай “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулах, тус гэрээний дагуу хүлээх мөнгөн хөрөнгийн гүйлгээ, зарцуулалт, эд хөрөнгийн аливаа эрх, барьцаа хөрөнгийг “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК-ийн бүрэн хяналтад байлгах үүргээ биелүүлэх зорилгоор Өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэл хангуулах барьцааны болон энэ төрлийн бусад шаардлагатай гэж үзсэн гэрээг “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК-тай байгуулах эрхийг тус тус Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

7. Өрийн хэрэгсэл гарган арилжаалах замаар татан төвлөрүүлэх санхүүжилтийн үүргийн гүйцэтгэл хангуулагчаар “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК ажиллахыг дурдсугай.
8. Өрийн хэрэгсэл гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж холбогдох баримт бичиг, бусад шаардлагатай гэрээ, хэлцэлд Компанийг төлөөлөн гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
9. Өрийн хэрэгсэл гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажилтай холбогдон гарах аливаа төлбөр, шимтгэл, хураамж, бусад зардлыг холбогдох гэрээ, хууль тогтоомжид заагдсан хугацааны дотор тухай бүр төлөх, Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулан ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
10. Өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой ажлын үйл явц, үр дүн болон энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тухай бүр танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн
23/27 тоот тогтоолын хавсралт



“ЛэндМН ББСБ” ХК-ийн өрийн хэрэгслийн ерөнхий нөхцөл*		Нөхцөл
Үзүүлэлт		Нөхцөл
1	Үнэт цаасны төрөл	Хаалттай хүрээнд арилжаалах өрийн хэрэгсэл
2	Үнэт цаасны нийт үнийн дүн	5,000,000,000 (таван тэрбум) төгрөг
3	Үнэт цаасны нийт тоо ширхэг	50,000 ширхэг
4	Нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
5	Нийт хугацаа	18 (арван найм) сар
6	Хүүгийн төрөл	Энгийн хүүтэй
7	Хүүгийн хувь хэмжээ (жилийн буюу 365 хоног)	18% (арван найман хувь)
8	Хүү төлөгдөх давтамж	Улирал тутам
9	Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	Хугацааны эцэст буюу 18 (арван найм) сарын дараа
10	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх буюу зээлийн эх үүсвэр бүрдүүлэх
11	Үүргийн гүйцэтгэл хангах төрөл	Барьцаа
12	Үүргийн гүйцэтгэл хангах арга	“АНД Системс” ХХК-ийн эзэмшиж буй 7,500,060,000 (долоон тэрбум таван зуун сая жаран мянга) төгрөгийн үнэлгээ бүхий 174,420,000 (нэг зуун далан дөрвөн сая дөрвөн зуун хорин мянга) ширхэг “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа
13	Эргэн дуудах нөхцөл	ТУЗ-ийн шийдвэрээр хугацаанаас нь өмнө эргэн дуудаж болно
14	Тусгай нөхцөл	Байхгүй
15	Андеррайтер	“Тэнгэр Капитал ҮЦК” ХХК
16	Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК

*Өрийн хэрэгслийг хэсэгчилсэн (транч) байдлаар гаргах тохиолдолд тийнхүү гаргах бүрд Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар анхдагч зах зээлд хэсэгчлэн гаргах Өрийн хэрэгслийн үнийн дүн, хэзээ гаргах хугацааг тогтооно.

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр

№ 23/28

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4, 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 23/27 тоот тогтоол, Компанийн ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн үнийн дүнтэй Компанийн өрийн хэрэгсэл (цаашид “Өрийн хэрэгсэл”)-ийн эргэн төлөлтийг баталгаажуулах шаардлага үүссэн тул Компанийн толгой компани болох “АНД Системс” ХХК нь өөрийн эзэмшиж буй, 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөрх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцоход 7,500,060,000 (долоон тэрбум таван зуун сая жаран мянга) төгрөгийн үнэлгээ бүхий 174,420,000 (нэг зуун далан дөрвөн сая дөрвөн зуун хорин мянга) ширхэг хувьцааг “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК, “ЛэндМН ББСБ” ХК-тай гурван талт “Хувьцааны барьцааны гэрээ” байгуулж, Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөж дуусах хүртэл хугацаагаар барьцаалуулахаар шийдвэрлэсэн болохыг тэмдэглэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан андеррайтер “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК болон барьцаалуулагч “АНД Системс” ХХК-тай гурван талт “Хувьцаа барьцааны гэрээ” байгуулахаар шийдвэрлэж, тус гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д зөвшөөрсүгэй.
3. Өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд хэсэгчлэн (транч) гаргах тохиолдолд андеррайтер “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК болон барьцаалуулагч “АНД Системс” ХХК-тай байгуулсан гурван талт “Хувьцаа барьцааны гэрээ”-ний дагуу барьцаалсан, энэхүү тогтоолын 1-т заасан хувьцааны нийт дүнгээс тийнхүү гаргаж буй Өрийн хэрэгсэл тус бүрээр тусгаарлуулах арга хэмжээ авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах, хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.ВОЛЖБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр

№ 23/29

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4, 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, 9.12 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс цаашид “ОНДО” ХХК-ийн дугаарыг хэрэглэж буй харилцагчид өөрийн үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээтэй холбоотой аливаа шаардлагатай мэдээллийг хүргэдэг болох зорилгоор “ОНДО” ХХК-тай “Тусгай дугаараас мессеж илгээх үйлчилгээний гэрээ” байгуулах хүсэлт гаргасантай танилцаад:
 - “ОНДО” ХХК нь Монгол Улсын үүрэн холбооны 5 дахь оператор компани бөгөөд цаашид тус компанийн дугаарыг хэрэглэдэг үйлчлүүлэгч тухайн дугаараар Компанийн үйлчилгээг ашиглах хүсэлт гаргах боломжтой болохыг харгалзан;
 - Компани нь өөрийн харилцагчид ямар операторын үйлчлүүлэгч гэдгээс үл шалтгаалан үйлчилгээгээ хүргэх зайлшгүй шаардлага байгааг харгалзан;
 - “ОНДО” ХХК-тай байгуулах “Тусгай дугаараас мессеж илгээх үйлчилгээний гэрээ”-ний нөхцөл нь зах зээлийн дундаж үнэтэй дүйцэхүйц байгааг харгалзан;

“ОНДО” ХХК-тай “Тусгай дугаараас мессеж илгээх үйлчилгээний гэрээ” байгуулахаар шийдвэрлэсүгэй.

2. “ОНДО” ХХК-тай байгуулах “Тусгай дугаараас мессеж илгээх үйлчилгээний гэрээ”-ний нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, уг гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

